



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 5/09

Баян-Овоо

Хүдэрзоригийн Минжээг Агац багийн
их эмчээр эргүүлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам" 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 6 дугаар хавсралт, 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд асрах чөлөөтэй байсан (Х.Минжээ)-г 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн Агац багийн их эмчээр эргүүлэн томилсугай.

2. Агац багийн их эмч (Х.Минжээ)-гийн үндсэн цалинг ТҮЭМ-5 шатлалаар сард 1,484,000 (Нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянга) төгрөгөөр бодож олгохыг нягтлан бодогч (Э.Ундармаа)-д зөвшөөрсүгэй.

3. Ажиллаж байх хугацаандаа ажилдаа хариуцлагатай, ёс зүйн алдаа зөрчил гаргахгүй, хариуцлагатай ажиллахыг Агац багийн их эмч (Х.Минжээ)-д үүрэг болгосугай.

ДАРГА *Б.Одмаа* Б.ОДМАА

